



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/6 47

Булган сум

Г Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай Г

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII хуралдааны 3 дугаар хавсралтын 2.19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засварын нэмэлт ажлыг 22,500,000 (хорин хоёр сая таван зуун мянга) төгрөгөөр “Өвөлжөөн булаг” ХХК-тай шууд гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн ашиглалтад оруулахыг “Өвөлжөөн булаг” ХХК (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засварын нэмэлт ажлын явцад хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засварын нэмэлт ажлын гэрээнд заагдсан санхүүжилтийг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засварын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ